



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/641

Мөрөн сум

“Ногоон бүс” төслийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цахим Хөвсгөл” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зөв зохион байгуулах, цахим эргүүл, хяналт шалгалтыг тогтмолжуулах зорилгоор “Ногоон бүс” теле хяналтын камерын төслийг хэрэгжүүлсүгэй.

2. “Ногоон бүс” теле хяналтын аюулгүй бүсийг бий болгох техникийн үзүүлэлт шаардлагыг зохих стандартад нийцүүлэн гаргаж, танилцуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, (цагдаагийн хурандаа А.Алтанцоож), төслийг дэмжиж, хариуцсан нутаг дэвсгэртээ оновчтой ажил арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. “Ногоон бүс” төсөлд зарцуулагдах зардлын бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг 2024 оны эхний хагас жилд багтаан шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа А.Алтанцоож) нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

